



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 318

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа,
үнийг шинэчлэн тогтоож, балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 6 нэрийн, 3,416,760.00 (гурван сая дөрвөн зуун арван зургаан мянга долоон зуун жар) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, яамны харьяа газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай;

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Тогтоолын биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ



132001629

16-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн
... дүгээр тогтоолын хавсралт

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ХАРЬАА БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦАА, ҮНИЙГ
ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Балансад бүртгэлтэй байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Балансын үнэ /хуримдлагдсан элэгдэл/ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон хугацаа /жилээр/	Шинэчлэн тогтоосон нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)	Хүлээн авах байгууллага
1	"Аялал жуулчлалын хөгжлийн төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	Ус цэвэршүүлэгч	2020.12.31	1	ш	842,160.00	2	336,864.00	336,864.00	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
2	"Аялал жуулчлалын хөгжлийн төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	Баримт үдэгч	2020.10.07	1	ш	190,000.00	2	76,000.00	76,000.00	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
3	"Аялал жуулчлалын хөгжлийн төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	Проектор	2020.12.31	1	ш	1,111,970.00	2	444,788.00	444,788.00	Ноён уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа
4	"Аялал жуулчлалын хөгжлийн төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	Печь	2020.12.31	1	ш	434,170.00	2	173,668.00	173,668.00	Ноён уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа
5	"Аялал жуулчлалын хөгжлийн төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	Өнгөт принтер Canon	2020.12.31	1	ш	658,460.00	2	263,384.00	263,384.00	Ноён уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа

6	Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа	Үлээгч аппарат	2015.07.24	1	ш	180,000.00	2	72,000.00	72,000.00	Ноён уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа
Нийт дүн				6.00	ш	3,416,760.00		1,366,704.00	1,366,704.00	
						(гурван сая дөрвөн зуун арван зургаан мянга долоон зуун жаран төгрөг)		(нэг сая гурван зуун жаран зургаан мянга долоон зуун дөрвөн төгрөг)	(нэг сая гурван зуун жаран зургаан мянга долоон зуун дөрвөн төгрөг)	